

## ХЯТАДЫН ҮНДЭСТНИЙ АСУУДАЛ БОЛОН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*Ч.Батцэцэг\**

Аливаа улс орны үндэстний бодлого нь тухайн газар нутагт оршин суух үндэстэн бүртэй холбоотой ямарваа нэг асуудлыг засгийн газраас удирдан зохицуулах чиг хандлагыг тогтоодог байна. Үндэстний бодлого өөрийн гэсэн мөн чанартай, тодорхой үйл явдалд хэрэгжин, ил тодоор тасралтгүй үргэлжлэн зохицуулагддаг асуудал юм. Орчин үед олон үндэстэнтэй улс орон нийтээрээ адил зөрчилтэй байх агаад тухайн орны соёл иргэншилд олон ургальч үзэл, улс төрийн нэгдэл болоод дотоодын бас бус зөрчлүүд оршсоор байна. Эдгээр зөрчлийг шийдвэрлэхэд төвөгтэй асуудал бол мэдээжийн хэрэг үндэстэн хоорондын бодлогыг амжилттай хэрэгжүүлж, чадварлаг зохицуулах явдал уг чанартаа асуудлын эх үүсвэр чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Олон угсаатан үндэстэнтэй улс орны хувьд тэр тусмаа өндөр хөгжилтэй орнуудад үндэстний бүтэц байдлыг илүү чухалчилан үздэг. Учир нь адил төстэй үндэстний тухайд тэд үндэстний онцлогоо нэгдүгээрт тавьдаг байна. Хүн төрөлхтөн бүр эртнээс суурьшиж ирсэн газар нутгийн үзэл, өөрөөр хэлбэл хүмүүсийн эртний хэл яриа, зан заншил, шашин шүтлэг, яс үндэс болон нутаг дэвсгэрийн байдал ямар байснаар илэрхийлэгддэг байна.

Хятад улсын түүхэнд үндэстний цөөнхийг “мань” /хятадын өмнө зүгт орших эртний овог/, “ди” /хятадын баруун хязгаарт орших эртний овог/, “жун” /хятадын баруун хэсгийн түрэг овгийнхон/, “и” /дорнодахины хятад биш ард түмэн/, “ху” /хойд зүгийн овгууд/ нар хэмээн нэрлэж байснаа Цагагчин гахай жилийн хувьсгалын үед “таван үндэстний улс” /хятад, манж, монгол, хотон, түвд/ болж, 1953 онд 400 гаруй угсаатан үндэстэн бүртгэгджээ. /1/ Одоо БНХАУ-д зонхилох хань үндэстнээс гадна 55 угсаатан үндэстэн аж төрж байна. Тэдгээр үндэстний хүн амын нийт тоо ойролцоогоор зуун сая гаруй буюу хятадын бүх хүн амын 8%-ийг эзэлж, нийт нутаг дэвсгэрийн 50-60 хувьд тархан

\*Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

байрладаг. Тэднийг үндэстний цөөнх гэж нэрлэх /энэ нь нэг тэрбумаас давсан хань үндэстэнтэй харьцуулсан утгаар хэлнэ/ ба гол төлөв Хятадын нутаг дэвсгэрийн баруун хойд, урд хэсэгт, зүүн хойд хязгаар нутаг, өмнөд мужуудад төвлөрөн суудаг байна. Тэдгээр нь өөрийн өвөрмөц соёл, зан заншил, бичиг үсэг, хэл яриа, шашин шүтлэгтэй, мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг. /2/

Олон үндэстэнтэй улс орны үндэстний бодлого зохицуулалт тухайн үндэстний улс төр, эдийн засаг, газарзүйн бүрэн бүтэн байдал бүхий талаар нөлөөлөх нь дамжиггүй. Хятад улс 50-иад оноос эхлэн үндэстнийг танин мэдэх ажлыг хоёр чиглэлээр авч үзэх болжээ. Үүнд: нэгдүгээрт, хил хязгаарын зарим нутгийн үндэстний овог аймгийг ялгаж салгахад харьцангуй төвөгтэй хэдий ч тэднийг орчин үеийн нийгэмд аажмаар шилжин орох урьдчилсан нөхцөл, нийгмийн зохион байгуулалт, хөгжлийн онцлог байдлыг ухамсарлан ойлгоход тус дөхөм болох ажлыг хэрэгжүүлэх: хоёрдугаарт, 1949 оноос хойш байнгын оршин суух журмын дагуу үндэстний эрх тэгш бодлогыг харилцан хүндэтгэх арга хэмжээ авч, оршин суугчдын бүртгэл хийж, “үндэстний бүтэц” зэргийг албан ёсоор бүртгэх болжээ. /3/

Харин БНХАУ дахь үндэсний үзлийн талаар анх удаа Хятадын Ардын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн Ерөнхий хөтөлбөрт /1949 онд/ харьцангуй албан ёсны байр суурь тусгагджээ. Хөтөлбөрийн 50-р зүйлд хоёр төрлийн үндэсний үзлийн эсрэг тэмцэх хэрэгтэйг заасан байна. Үүнд: их үндэсний үзэл өөрөөр хэлбэл их хань үндэсний үзэл болон орон нутгийн бага үндэсний үзэл багтана./4/ Мао Цзэдун их үндэсний үзлийн эсрэг тэмцэх талаар өгүүлэхдээ: “БНХАУ-ын зарим үндэстний өөртөө засах оронд үндэстний харилцаа огт хэвийн бус байна”. Учир нь их хань үндэсний үзэл “намын гишүүд, албан хаагчдын дунд нэлээд түгээмэл байна” гээд ард олны дунд ч мөн байна гэжээ. Үүнээс хойш гурван жилийн дараа Мао Цзэдун дахин чухал тодотгол хийсэн байна. Тэрбээр “бид их хань үндэсний үзлийн эсрэг тууштай тэмцэл явуулахын сацуу хэдийгээр онц шаардлагагүй ч орон нутгийн үндэсний үзлийн эсрэг бас тэмцэх хэрэгтэй” /5/ гэсэн байна.

1957 онд ХКН-аас орон нутгийн үндэсний үзэлтэй хийх тэмцэлд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж уриалжээ. Энэ байр суурийг Дэн Сяопин ХКН-ын Төв Хорооны 8 дахь удаагийн Ш бүгд хурал дээр тавьсан өөрийнхөө илтгэлд тусгасан байна. /6/ Ийнхүү орон нутгийн үндэсний үзэл “гол аюулд” тооцогдох болов.

Үндэстний харьцааны тухай онолоор бол үндэстний хэсэг болон их үндэстний овог аймгийн адил төстэй нэг үндэстний ээдрээтэй шинж чанарыг заавал нэг төвшинд гаргаж тавьдаг байна. Тэр нь засгийн газрын зөв мэргэн бодлого, үндэстний бодлого боловсруулалтын үр дүн, түүний хэрэгжилт, зохицуулалт гэсэн үзүүлэлтээр илэрдэг ажээ. Энэ нь нэгд, тухайн олон угсаатан үндэстний овог аймгийнхан бүгд ямар ч зовлон бэрхшээлгүй, өөр өөрийн үндэстний цусан төрлөөрөө цэцэглэн хөгжиж, үндэстний соёл уламжлалаа хадгалан, хойч үедээ өвлүүлэн залгамжлуулж аль болох таатай нөхцөлд нэг төрлийн иргэний нийгмийг бүрдүүлснээр өөрийн болон нийгмийн цогц зорилт, үндэстний нийгмийн байдлыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх хоёрт, тухайн нэг үндэстний хэсэг буюу зарим нэг овгийнхон ажил мэргэжил, засаг захиргааны эрх мэдэл, албан тушаалтай болох, боловсрол эзэмших, улсаас зээл авах, хөрөнгө оруулалт хийх зэрэг боломжийг олж авч байгаатай нэгэн адил гадаадад цагаачлан амьдардаг, боломжоор хир тааруу цөөн үндэстний нийгмийн байдал устгагдаж буй нь тэднийг эвсэн нэгдэх тэмцэлд уриалах чухал суурь нөхцөл болдог байна. Иймээс үүнийг шийдвэрлэхийн тулд үндэстний бодлого боловсруулалт, зохицуулалт нь зарим нөхцөл байдалд эсрэгээр нөлөөлж асуудлын өдөөгч болон хувирдаг тал бий.

Хятадын зарим үндэстний цөөнхийн салаа салбар адилгүй учраас дан ганц үндэстний хөгжлийн хандлагаас болж шаардлага хүчтэй тавих, хүн ам өсөн нэмэгдэх ялгааг зогсоох, цөөнх үндэстний хүн амын механик өсөлтийг нэмэгдүүлэх, зарим орон нутгийн засгийн газар хаана хаанаа ашигтай хууль тогтоол батлах, уг засаг захиргааны нэгжийн хуваарилалтанд тэдний үндэстний харьцааг нарийвчлан гаргах, өөртөө засах орон болгох зэрэг шаардлагууд гарсаар байгаа ажээ. Хятадын Үндэстний Хороо, Цагдаагийн байгууллагатай хамтран “Үндэстний бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай асуудлыг түр зогсоохтой холбогдсон ажлын мэдэгдэл” /1989 онд/ гаргасан байна. Уг мэдэгдэлд: эдийн засгийн онцгой бүс нутагт хамаарахгүй буюу хүн ам олонтой үндэстний бүрэлдэхүүнийг өөрчлөх, үндэстний эв нэгдэлд саад хийх, шаардлагагүй маргааныг аль болохоор гаргахгүй байх тухай заажээ. Нөгөөтэйгүүр энэ бодлого боловсруулалт, зохицуулалтыг хийхдээ богиноос урт хугацааны зорилт болгохоор нарийвчилж төлөвлөх хэрэгтэй /7/ гэсэн байна.

Хятадын Үндсэн хуульд “үндэстний эв нэгдлийн төлөө тэмцэлд их үндэстний үзлийг эсэргүүцэх хэрэгтэй. Ялангуяа их хань үндэстний

үзэл болон орон нутгийн үндэсний үзлийг эсэргүүцэх хэрэгтэй” /8/ гэсэн боловч уг чанартаа хань үндэстэн, цөөнх үндэстний аль аль нь ялгаагүй үндсэрхэх үзлийн талаар дэвшүүлсэн хууль тогтоолыг бүрэн ухамсарлаж буй ч зөрчсөөр л байна. Нэг хэсэг нь их үндэстний үзлийг дэвэргэхийг эсэргүүцэх хэрэггүй, зөвхөн их хань үндэстний үзлийг эсэргүүцэж болно гэж байхад, зарим нь хань үндэстэнд их үндэсний үзэл байхад цөөнх үндэстэнд мөн их үндэсний үзэл байх л ёстой хэмээн зөрчилдөж байна. Ийнхүү хоёр төрлийн үндсэрхэх үзлийг эсэргүүцэж хэн нь гол эзэн байх асуудлын талаар маргалдсаар иржээ.

Түүхийн урт хугацаанд хань үндэстний хүн ам олон, эдийн засаг, соёлын төвшингөөр бусад цөөнх үндэстнээсээ илүү, хань үндэстний ноёрхогчид цөөнх үндэстнээ дарангуйлан ноёрхож байв. Иймээс улсын хэмжээнд нийтээрээ голдуу их хань үндэсний үзлийг эсэргүүцэж байсан аж. Нөгөөтэйгүүр цөөнх үндэстний бүс нутаг, муж, орон нутгийн хэмжээнд цөөнх үндэстний өөрийн их үндэсний үзэл буюу орон нутгийн үндсэрхэх үзэл гарч буй нь гол зөрчил болж байна. Энэ утгаар хоёр төрлийн үндсэрхэх үзэл оршиж буй газарт аливаа үндэсний үзлийг гаргахгүй байх, зөрчлөөс аль болохоор зайлсхийх хэрэгтэйг номлож, энэ нь үндэстний эв нэгдэлд сөргөөр нөлөөлж, үүнтэй холбогдох ямарваа нэг асуудлыг шийдвэрлэхдээ хэрэг явдлаас болгоомжилж, хөнгөн хуудуу хандаж болохгүйг анхааруулсаар ирсэн байна.

Харин 80-аад оны эхнээс ХКН-аас их үндэсний үзлээс орон нутгийн үндэсний үзлийн эсрэг тэмцэлд гол анхаарлаа хандуулж байсан алдаагаа хүлээн зөвшөөрчээ. 90-ээд оны эхэн үед БНХАУ-д үндэсний үзлийн талаар албан ёсны номлолд өөрчлөлт гараагүй байна. Энэ үед үндэсний үзлийн талаар маргааныг таслах аргазүйн асуудлыг ч маш цөөн хөнджээ. Үндэстний асуудлаар мэргэжсэн эрдэмтэн Лю Сяньчжао “Үндэстний асуудлын үндсэн онолууд” хэмээх өгүүлэлдээ: “хятадын доторхи үндэсний үзэл” нь их хань үндэсний үзэл болон орон нутгийн хятад бус үндэсний үзэлд хуваагддаг. Энэхүү үндэсний үзэл хоёулаа “дарлагдагч ангийн үзэл суртлын” өнгөрсөн үеийн үндэслэлийг хуучин үзэл сурталтай адил тэнцүү тавьдаг. Их хань үндэсний үзэл хань бус үндэстний эрхийг зөрчих, тэднийг дарамтлах зэргээр илэрдэг бол орон нутгийн үндэсний үзэл “тусгаарлагдмал болон бусад үндэстнээс хөндийрөн зайлсхийсэн, хүнд сурталтай байдлаар илэрдэг /9/ гэжээ.

XX зууны 90-ээд оны дунд үеэс БНХАУ-д хятадын үндэсний үзлийг олон угсаатан үндэсний үзэл болгох төслийг эрчимтэй хэлэлцэж

эхлэх нөхцөл байдал бүрдсэн юм. Ер нь хятад үндэстэн гэдэг нь зөвхөн “хятадын соёлын өв баялагыг хадгалсан олон ургальч үзлийг нэгтгэсэн цогц” гэхээсээ илүү үндэстний тусгаар тогтнолын эрхийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн нэгдэл гэдэг утгаар давамгайлж байна. Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Үндэстний судлалын Хүрээлэнгийн эрдэмтэн Ван Сиэнь өөрийн бичсэн зохиолдоо “үндэстний үзлийн асуудал нь эдийн засгийн хөгжил, шинэчлэлийн үйл явцыг ойлгох хүрээнд явагдаж байна” гэж дүгнэсэн байна./10/ Хятадын эрдэмтдийн олонхи нь үндэстний үзэл бол үзэл суртлын хувьд нэгдмэл хятад үндэстэн “чжунхуа миньцзу”-д үйлчилж, энэ үзэл суртал нийт үндэстний бүх анги давхрагад хамаарна гэж үзэж байна.

Үндэстний цөөнхийн бүс нутгийн ард түмний дунд шашин шүтлэг нэлээд түгээмэл учраас шашины болон үндэстний асуудал нягт холбоотой явж иржээ. Иймд сүсэг бишрэлийг чөлөөтэй болгох оновчтой зөв бодлогыг амьдралд хэрэгжүүлэхийн тулд шашин шүтлэгийн хэв хэмжээ, зүй тогтол, үйл ажиллагааг амжилттай зохицуулснаар сая эдийн засгийн шинэчлэлтийн бүтээн байгуулалтанд үйлчлэх болно гэж хятадын эрдэмтэд үзэж байна.

Хятад улс байгуулагдсаны дараагаас өдгөө хүртэл хятадын хил хязгаар дотор оршин суух олон угсаатан үндэстний бодит байдалд тохируулан үндэстний бодлогыг боловсруулж, тэдний байр суурь, эрх тэгш байдлыг хууль тогтоолоор баталгаажуулж, цөөнх үндэстэн бүгд амьдрах, хөгжих, суралцах, улс төр, эдийн засгийн бүтээн байгуулалт, соёлын арга хэмжээнд оролцох зэрэг бүхий л салбарт давуу эрх эдлэх талаар улсын хууль тогтоолоор хамгаалагдсан байна. Гэвч үндэстний цөөнхийн ард түмний дунд шашин шүтлэг, үзэл суртлын зөрчлүүд үүсч буйн гол шалтгаан нь нэгдүгээрт, тэднийг хавчин гадуурхах, дарамтлах, тэрслүү үзэлтний нэрээр хүний эрхийг зөрчих, хоёрдугаарт, цөөнх үндэстний өөрсдийн нь боловсролын төвшин доогуур зэргээс болдог ажээ.

Хятад улс үндэстний цөөнхийн бүс нутгийг хөгжүүлэх эдийн засгийн чиг шугамдаа бүс нутгийн эдийн засгийн хөгжилтөнд зохицуулалт хийж, үндэстний цөөнхийн бүс нутгийн хөгжлийн ялгааг аажмаар багасгах талаар тодорхой бодлого баримталж, төсөл хэрэгжүүлж байна. Үүнд: нэгдүгээрт, баруун бүсийн үндэстний цөөнхийн нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёрдугаарт, дорно-өрнийн бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гуравдугаарт, үндэстний цөөнхийн бүс нутгийн ажлын хүчийг нэмэгдүүлэх,

дөрөвдүгээрт, хил орчмын цөөнх үндэстний бүс нутгийг нээлттэй болгох талаар идэвхтэй дэмжиж бүтээн байгуулалтын ажлаа эрчимтэй эхлээд байна. Ийнхүү цөөнх үндэстний бүс нутагт орчин үеийн техник технологийн хөгжлийн үр дүнд эдийн засгийн шинэ төсөл, томоохон бүтээн байгуулалтыг дагалдан хань үндэстний ажлын хүч маш олноороо ирж суурьших болжээ. Энэ нь нэг талаар тухайн цөөнх үндэстний бүтэц бүрэлдэхүүнд сөргөөр нөлөөлөх талтай ч нөгөөтэйгүүр эдийн засгийн хөгжлийн хирээр нэгдмэл хятад үндэстэн “чжунхуа миньцзу” гэдгээрээ бахархах үзэл газар авч, хятад үндэстэн дэлхийд шийдвэрлэх дуу хоолойтой үндэстэн гэсэн ойлголт нэгэнт бий болжээ.

Орчин үед БНХАУ-ын эдийн засгийн бодлого амжилттай хэрэгжихийн сацуу байр суурь нэр хүнд нь өсөн нэмэгдэж, олон улсын тавцан дээр их гүрний бодлого явуулж байна. XXI зуунд Хятадад үндэстний үзлийг хэрхэн тодорхойлох, эх оронч үзэлтэй хэрхэн уялдуулах талаар эрдэмтэд дорвитой судалгаа хийж онолын маргаан явуулан өөрсдийн үзэл бодол, саналаа дэвшүүлсээр байна. Судлаачдын дийлэнхи нь Хятадад улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд гол хөдөлгөгч хүч болохуйц үйл ажиллагаатай үндэстний үзэл хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байгаа юм байна. Зарим эрдэмтэд нэгдмэл хятад үндэстэнг “чжунхуа миньцзу” Күнзийн сургаал дор нэгтгэсэн үндэстний үзлийг хөгжүүлэх ёстой гэж үзэж байна. Күнзийн сургаалын угсаатан төвт үзлийн үндэс нь орчлон ертөнц, хятадын эзэнт улс хоёрыг адилд үздэг ажээ. Күнзийн сургаал ёсоор ертөнцийн бүх хүнийг “тэнгэрийн хүү” буюу хятадын эзэн хаан захирах ёстой бөгөөд Хятад орон дэлхийн “төв” учраас “Чжунго” буюу “Дундад улс” мөн, харин бусад бүх орон “тэнгэрийн хүү”-гийн ертөнцийг засан тохинуулах нөлөөн дор орших ёстой хэмээн үздэг байна. Күнзийн сургаал нь хятадын уламжлалт нийгмийн үндсэн илэрхийлэл болж байгаа ч өнөөгийн нөхцөлд түүнийг бусад нийгмийн нөхцөлтэй зэрэгцүүлэн тавих боломжгүй. Энэ нь Хятад улс эдийн засгийн хувьд хүчирхэгжин хөгжих тусам хятадын их гүрний үзэл мөн төдийчинээ илэрч байгаагийн шинж буюу.

XXI зуунд хятадын үндэстний үзлийн хэтийн төлөвийн тухай нэгдмэл хятад үндэстэн “чжунхуа миньцзу” хятад эх орноо дэмжиж түшиглэсэн эх оронч үзлээр үргэлжлэн оршин тогтнож хөгжих болно гэж заасан байна. Хятад дахь үндэстний үзэл цаашид хэрхэн хөгжихийг амьдрал өөрөө харуулах буй заа.

**ИШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Нэймэнгу да сюе бао /Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг/ Хөх хот, 2001 №4/33/ т. 78
2. Ч.Батцэцэг. БНХАУ-ын үндэстний цөөнхийн бүс нутгийн нийгэм эдийн засгийн байдал ба үндэстний асуудал. “БНХАУ-ын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого” УБ, 1999. т. 107
3. Нэймэнгу да сюе бао /Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг/ Хөх хот, 2001 №4/33/ т. 79
4. Проблемы Дальнего Востока. 2001, №8 т. 47
5. Пипинь да хань цзу чжу и Мао Цзэдун сюаньцзи /Их хань үндэстний үзлийг шүүмжлэх нь/ Мао Цзедуны түүвэр зохиол. 1977 он 5-р боть т.75-76
6. Дэн Сяопин. Гуаньюй чжэнфэн юньдун дэ бао гао. Гуаньюй шаошу миньцзу. /Чжэнфэн хөдөлгөөний тухай илтгэл. Цөөнх үндэстний тухай/ ХКН-ын түүхийн лавлах материал. Бээжин, 1962. т. 359-360
7. Нэймэнгу да сюе бао /Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг/ Хөх хот, 2001 №4/33/ т. 80
8. Чжун ян миньцзу дэ цзигэ цзибэнь лилунь вэньти. “Минь цзу яньчжу” сэтгүүл. 1999 №2 т. 9
9. Ван Сиэнь. Миньцзу гочэн юй гоцзя /Үндэстний явц болон улс/ Ланьчжоу, 1998 т. 161-162